

Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс

# ӨМНӨГОВЬ-2018

**Статистикийн 95 жилийн ойд зориулав.**

Эмхэтгэсэн: У.Хоролмаа

Хянасан: С.Бямбабаатар

**Даланзадгад**

**2019 он**

# АГУУЛГА

Өмнөх үг

Өмнөговь аймгийн тухай

БҮЛЭГ 1. Хүн ам зүйн байдал

БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлт

БҮЛЭГ 3. Нийгмийн үйлчилгээний салбарууд

3.1 Боловсрол, соёл, урлаг

3.2 Эрүүл мэнд

БҮЛЭГ 4. Дотоодын нийт бүтээгдэхүүн, төсөв санхүү

БҮЛЭГ 5. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ. тариф

БҮЛЭГ 6. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд

6.1 Хөдөө аж ахуй

6.2 Аж үйлдвэр

6.3 Барилга, тээвэр

БҮЛЭГ 7. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтэц

Хавсралт

## Өмнөх үг

Аймгийн статистикийн хэлтэс нь орон нутгийн хэмжээнд статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар танилцуулга, судалгаа бэлтгэж тархаах үндсэн чиг үүрэгтэй 10 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндсэн 5 ажилтан, гэрээт 1 ажилтан, өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний судалгааны гэрээт судлаач 2 ажиллаж байна. Үндсэн ажилтнууд бүгд статистикч, эдийн засагч, мэдээлэл технологийн чиглэлийн мэргэжлийн ажилтнууд байгаа бөгөөд судлаачид ч мөн статистикч, эдийн засагч болон нийгмийн салбарын мэргэжилтэй хүмүүс байна.



Хэрэглэгч та бүхэнд толилуулж буй Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын энэхүү танилцуулга, холбогдох тоо мэдээллийг аймаг, орон нутгийнхаа хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах болон шинжилгээ судалгааны ажилд өргөнөөр ашиглахыг хүсье.

Танилцуулгын болон статистикийн мэдээллийн талаар өөрийн санал хүсэлтээ бидний хаягаар ирүүлбэл талархан хүлээн авч хамтран ажиллах болно.

Хаяг: Өмнөговь аймгийн Удирдлагын ордон, өрөө 303, 304

Утас: 70533061

70533439

Цахим хаяг: [umnugovi@nso.mn](mailto:umnugovi@nso.mn)

Веб хуудас: <http://www.umnugovi.nso.mn/>

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**


## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТУХАЙ



Төрийн дээд шагнал “Алтан гадас одонт, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Өмнөговь аймаг нь 1931 онд Богд Хан-Уул, Цэцэрлэг Мандлын аймгуудаас таслан Говь Гурвансайхан уулын зүүн урд энгэрт, “Далан булаг” хэмээх газар байгуулагдсан. Эдүгээ 88 жилийн арвин их түүхтэй. МУ-ын өмнөд цэгт байрлах ба хамгийн их нутаг дэвсгэртэй буюу 165 мян хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа, Баяннуур аймгуудтай хиллэдэг бол хойд хэсгээрээ МУ-ын Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудтай хил залгаа оршдог. Аймгийн төв Даланзадгад нь нийслэл Улаанбаатар хотоос 570 км зайтай. Засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 59 багтай. Төрийн 149 байгууллагын 3923 төрийн албан хаагч ажилладаг.

Байгаль цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус хүрдэг онцлогтой.

Байгалийн үзэсгэлэнт Хонгорын голын элсэн уул, Монголын алдарт 33 говийн нэг Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говь, 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг палентологийн олдворууд олдсон Баян заг, дэлхийд ховорт тооцогдох Нэмэгт, хэрмэн цав, Шаригийн ганга, Бүгийн цав, зэрэг байгалийн тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд олон бий. Ан амьтан араатан жигүүртэн, ховор нандин ургамлаар баялаг сүрлэг сайхан Говь гурван сайхан Ёлын ам, Мухар шивэртийн ам зэрэг нь гадаад дотоодын жуулчдын харааг татаж сэтгэлийг хөдөлгөж Өмнөговьчууд үзэсгэлэнт онгон дагшин байгалиараа дэлхийд гайхагдаж байна. Түүнчлэн Ноён Хутагт Данзанравжаагийн байгуулсан дэлхийн энергийн төв Дэмчогийн хийд, дэлхийд данстай галбын улаан, ханын хэцийн хүрэн тэмээд, хараа цуцаам уудам тал, говь хангай хосолсон байгалийн үзэсгэлэн олонтаа билээ.



Манай аймаг нь 68114 хүн амтай. МУ-ын үнэт эрдэнэ хүүхэд залуусын боловсрол мэдлэгт онцгой анхаарч сургууль, цэцэрлэгийг шинээр барьж ашиглалтад оруулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар манай аймагт Ерөнхий боловсролын 22 сургууль, Сургуулийн өмнөх боловсрол олгох 29 цэцэрлэг ажиллаж байна.

Хүн ардын эрүүл мэндийг дэмжсэн үндэсний болоод орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах ажлууд шат дараатай хийгдэж байна. Эрүүл мэндийн 94 байгууллага ажиллаж буйгаас улсын эмнэлэг 17, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 27, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 189 их эмч, 362 дунд мэргэжилтэн ажиллаж байна.



Өмнөговь аймаг нь 2,6 сая тоо толгой мал сүрэгтэй. 5951 малчин өрхтэй. 2018 оны жилийн эцэст 152 мян тэмээн сүрэг тоолуулж Хоёр бөхт тэмээн сүргээрээ улсдаа тэргүүлсээр байна.

Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Тавантолгой, Оюу толгой, Нарийнсухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газарт тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Терра энерги,

Жавхланта орд зэрэг 14 компани ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. МУ-ын нүүрс экспортын дийлэнх хувийг Өмнөговь аймаг бүрдүүлж байна. 2018 онд улсын хэмжээнд 36,6 мян тонн нүүрс экспортлсноос Өмнөговь аймаг 33,4 мян тонн буюу 90 хувийг экспортолжээ.

2006 оноос аймаг өөрийгөө бүрэн санхүүжүүлж орон нутгийн төсвийн орлогод 2018 онд 163.7 тэрбум төгрөг төвлөрүүлж төсвийн орлого 2016 оноос 49.2 тэрбум төгрөгөөр өссөн төдийгүй аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавхи 2018 онд 229.0 хувьтай байна. Орон нутгийн төсвийн давсан орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогоор 2018 онд улсын хэмжээнд нийслэлийн дараа, аймгуудаас хамгийн өндөр орлого төвлөрүүлсэн үзүүлэлттэй тэргүүлж байна. 2018 онд 66,1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь 2016 оноос 4 дахин, 2017 оноос 2,2 дахин өссөн төдийгүй төлөвлөгөөгөө бүрэн биелүүлсэн байна.

#### ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, сумаар

Сумын нэр	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.кв.км	Хүн амын нягтшил /1 км <sup>2</sup> -т ногдох хүн/
<b>Дүн</b>	<b>59</b>	<b>165.4</b>	<b>0.41</b>
Баяндалай	3	10.8	0.19
Баян-Овоо	3	10.5	0.17
Булган	4	7.5	0.28
Гурвантэс	5	27.9	0.18
Мандал-Овоо	3	6.4	0.26
Манлай	4	12.4	0.21
Номгон	5	19.5	0.07
Ноён	2	10.6	0.24
Сэврэй	3	8.1	0.25
Ханбогд	5	15.2	0.50
Ханхонгор	4	9.9	0.20
Хүрмэн	3	12.4	0.13
Цогт-Овоо	3	6.5	0.28
Цогтцэций	4	7.2	1.09
Даланзадгад	8	0.5	52.29

Бүлэг 1



## Хүн амын тоо, түүний өсөлт, өөрчлөлт

Монгол улсын нийт хүн ам 2018 онд 3,238,479 болж өмнөх оноос 60,580 буюу 1.91 хувиар өссөн. Өмнөговь аймгийн хүн амын тоо нь сүүлийн жилүүдэд өссөөр байна.

Өмнөговь аймаг 2018 оны эцэст 68,114 хүн амтай болж 2017 оны эцсийн хүн амаас 3.7 хувиар буюу 2,469 хүнээр өслөө. Нийт хүн амын 32.7 хувийг 0-15 насны хүүхэд, 61.4 хувийг 16-59 насны, 5.9 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна.


### Хүн амын тооны динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:

*Хүснэгт 1*

Он	Хүн амын тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд %	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2008	47784				
2009	50681	2897	106.1	6.1	474.9
2010	52306	1625	103.2	3.2	507.8
2011	53891	1585	103.0	3.0	528.3
2012	56585	2694	105.0	5.0	538.8
2013	58555	1970	103.5	3.5	562.9
2014	59665	1110	101.9	1.9	584.2
2015	61540	1875	103.1	3.1	604.8
2016	63661	2121	103.4	3.4	623.8
2017	65645	1984	103.1	3.1	640
2018	68114	2469	103.8	3.8	649.7

Дараах графикаас харахад суурин хүн амын тоо сүүлийн жилүүдэд жил дараалан өссөн байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар 68,114 болж 2008 оноос 42.5 хувиар, 2010 оноос 30.2 хувиар тус тус өссөн байна.

*Зураг 1*



Өмнөговь аймагт нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2000 онд 0.28 хүн ногдож байсан бол 2018 онд 0.37 болж нэмэгджээ. Сумын хүн амын нягтралын өөрчлөлтөд ердийн цэвэр өсөлтөөс гадна дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн байна.

Монгол Улс нь нэг хавтгай дөрвөлжин километр ногдох хүний тоогоор дэлхийн бусад улс оронтой харьцуулахад сийрэг суурьшилтай орнуудын тоонд ордог. Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2018 онд 2.1 болсон байна.

ЗУРАГ 1.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2018 ОН



Аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хот нь Монгол улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг хэрнээ хүн амын нягтралаар хамгийн өндөрт орж байна. 2018 оны байдлаар Улаанбаатар хотын нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 317.3 хүн ногдож байгаа нь өмнөх оныхоос 6 хүнээр нэмэгджээ. Бусад аймгуудын хүн амын нягтралыг харахад газар нутгийн хэмжээ, хүн амын тооноосоо шалтгаалан харилцан адилгүй, тухайлбал Орхон, Дархан-Уул аймаг нь бусдаас хамгийн өндөр, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад хамгийн бага буюу нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт нэг хүрэхгүй хүн ногдож байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төврүү чигэлсэн байгааг илэрхийлж байна.

**Хүн амын тоо суурьшлын байдлаар Аймгаар 2014-2018 он /хот, хөдөө /**

*Хүснэгт 1.2*

Он	Аймгийн төв		Сумын төв		Хөдөө	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
2014	21835	11333	20770	10219	17058	8321
2015	22602	11812	20055	9908	18883	8798
2016	24861	13015	21207	10555	17593	8131
2017	25016	13119	22623	11071	17936	8438
2018	26143	13694	18109	8764	23862	11420

2018 онд аймгийн төвийн хүн ам суурь оноос 15.7 хувиар, өмнөх оноос 4.5 хувиар өсч, сумын төвийн хүн ам суурь оноос 9.7 хувиар, өмнөх оноос 20.0 хувиар тус тус буурсан байна. Хөдөөгийн хүн амын тоо 2010 оноос 23.6 хувиар буурч, 2015 оноос 26,4 хувиар өмнөх оноос 33.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Хүн амын хүйс

Хүн амын бүтцэд хүн амын нас, хүйсийн байдал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, түүний шалтгаан зэрэг нь тухайн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалтай уялдсан байдаг.


### Хүн амын тоо хүйсээр 2008-2018 он

Хүснэгт 1.3

Он	Хүн амын тоо			Дүнд эзлэх хувийн жин		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2008	47784	23445	24339	100.0	49.1	50.9
2009	50681	24995	25686	100.0	49.3	50.7
2010	52306	25885	26421	100.0	49.5	50.5
2011	53891	26744	27147	100.0	49.6	50.4
2012	56585	28146	28439	100.0	49.7	50.3
2013	58555	29129	29426	100.0	49.7	50.3
2014	59665	29792	29873	100.0	49.9	50.1
2015	61540	31020	30520	100.0	50.4	49.65
2016	63661	31960	31701	100.0	50.2	49.8
2017	65645	32986	32659	100.0	50.2	49.8
2018	68114	34232	33882	100.0	50.3	49.7

2018 оны байдлаар аймгийн хүн амын 50.3 хувийг эрэгтэйчүүд, 49.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 34232 нь эрэгтэй байгаа нь 2010 оноос 32.2 хувиар, 2015 оноос 10.4 хувиар, өмнөх оноос 3.8 хувиар өсч, Үүнээс эмэгтэй нь 33882 болж 2010 оноос 28.6 хувь, 2015 оноос 11.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1.2. ЭРЭГТЭЙ. ЭМЭГТЭЙ ХҮН АМЫН ХУВИЙН ЖИН 2018 ОН



### Өмнөговь аймгийн шилжих хөдөлгөөн

Зураг 1.3



Өмнөговь аймгийн хүн амд шилжин ирэгсэд нь 2018 онд 2015 болж , 2010 оноос 36.4 хувиар буурч, 2015 оноос 78.3 хувиар, 2017 оноос 24.5 хувиар өссөн байна. Харин шилжин явсан хүн ам нь 2018 онд 2009 болж 2010 оноос 10 хувиар буурч, 2015 оноос 46.7 хувиар, өмнөх оноос 1229 хүнээр өссөн байна.

### Төрсөн хүүхдийн тоо, хүйсээр, оны эцэст

Хүснэгт 1.4

Он	Бүгд	Үүнээс:		Улсын дүнд эзлэх хувь	1000 хүнд ногдох төрөлт
		Эрэгтэй	Эмэгтэй		
2012	1490	752	738	2.02	26.9
2013	1796	917	879	2.25	31.2
2014	1607	845	762	2.00	24.3
2015	1668	861	867	2.06	27.5
2016	1613	808	805	2.02	25.7
2017	1473	768	705	2.01	26.3
2018	1858	932	924	2.36	27.2

Төрсөн хүүхдийн тоо 2018 онд 1858 байгаа нь 2015 оноос 11.4 хувиар өмнөх оноос 26.1 хувиар өссөн байна. Аймгийн хүн амын 1000 хүнд ногдох төрөлт 2018 онд 27 болж 2008 оноос 2 төрөлтөөр, 2010 оноос 5 төрөлтөөр, 2017 оноос 1 төрөлтөөр тус тус өссөн байна. Харин 2013 оноос 4 төрөлтөөр буурсан харагдаж байна.

Хүн амын өсөлт, өөрчлөлтийг шууд тодорхойлдог төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн гэсэн 3 үндсэн үзүүлэлтээс төрөлт нь хүн амын өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг гол хүчин


зүйл мөн.Төрөлт нь зөвхөн хүн амын тоо хэмжээнд нөлөөлөөд зогсохгүй нас , хүйсийн бүтцэд ч нөлөөлдөг.

## ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Манай улсын нийт өрх гэрийн тоо 1960-1980-аад онд 26.9 хувь өссөн нь өрхийн өсөлтийн оргил үе байсан байна. Энэ нь тухайн үеийн нам, засгаас гэрлэлтийг болон олон хүүхэд төрүүлэхийг дэмжих бодлого явагдаж, тэдгээрийг урамшуулах олон төрлийн арга хэмжээ авч байсантай холбоотой юм. 1990 оноос гэрлэлт цөөрч, өрхийн өсөлт буурч эхэлсэн байна. Аймгийн Өрхийн тоо 2018 онд 21983 болж 2010 оноос 36.4 хувиар, 2015 оноос 9.9 хувиар, 2017 оноос 3.3 хувиар тус тус өссөн байна. Өрхийн тооны өсөлт бууралт нь өрхийн гишүүдийн тоотой салшгүй холбоотой байдаг.


Өмнөговь аймгийн хувьд 1 өрхөд ногдох өрхийн гишүүдийн тоог онуудаар авч үзвэл:

2014 онд– 3.0  
2015 онд – 3.0  
2016 онд – 3.1  
2017 онд – 3.1  
2018 онд – 3.1



## 2008-2018 оны өрхийн тоо

Зураг 1.5



Дээрх үзүүлэлтээс харахад 2018 оныг 2015 оны үзүүлэлттэй харьцуулбал 1 өрхөд ногдох гишүүдийн тоо 0.1 нэгжээр өсч өмнөх онтойгоо адилхан байна.

### Гэрлэлт


Хүн амын гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн шинжлэх ухаанд гэрлэлт, салалт, бэлбэсрэлт, тусгаарлалт, дахин гэрлэлт зэрэг ухагдахуунуудын цогцоор илэрхийлэгддэг. Гэрлэлт гэдэг нь хүмүүс гэр бүлээ албан ёсоор бүртгүүлэх явдлаар илэрхийлнэ. Манай аймгийн хувьд гэрлэлтийн түвшин чиг хандлага ямар байгааг авч үзье.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2018 онд нийт 343 хос гэрлэлтээ батлуулж 2010 оноос 2.1 дахин, 2015 оноос 42 хувиар, 2017 оноос 43 хувиар өссөн байна.

2008 - 2009 онуудад гэрлэлт өссөн нь шинээр гэр бүл бологсдыг дэмжиж мөнгөн тэтгэлэг олгож эхэлсэнтэй шууд холбоотой юм. 2010 оны хувьд гэрлэлт буурсан нь гэр бүл бологсдыг дэмжих мөнгөн тэтгэлэг олгохдохоо больсонтой холбож тайлбарлаж болох юм.

### Өмнөговь аймгийн гэрлэлт 2008-2018 оны байдлаар

Зураг 1.4



Гэрлэлтийн тоо буурахад бусад гэрлэлтийн коэффициентууд дагаад буурдаг нь хуультай. 2018 онд Өмнөговь аймгийн 1000 хүн тутамд 5 гэрлэлт ногдож байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

# Бүлэг 2



Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар эдийн засгийн идэвхитэй хүн ам 1358.6 мянган хүн байгаагийн 92.2 хувь нь ажиллагчид, 7.8 хувь нь ажилгүй иргэд байна. Эдийн засгийн идэвхитэй эмэгтэйчүүдийн тоо 628.0 мянга байна.

**ХҮСНЭГТ 2.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД. 2010-2013 он**

	Эдийн засгийн идэвхтэй хүн ам. мян.хүн		Ажиллагчдын тоо. мян.хүн		Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	
	Улсын дүн	Өмнөговь аймаг	Улсын дүн	Өмнөговь аймаг	Улсын дүн Мян.хүн	Өмнөговь аймаг
<b>2014</b>	1127.7	30.3	1040.7	26.9	87.0	3411
<b>2015</b>	1164.0	29.0	1067.5	25.6	96.4	3433
<b>2016</b>	1239.8	28.3	1132.8	24.3	107.0	4056
<b>2017</b>	1367.2	30.2	1266.9	25.3	100.3	4970
<b>2018</b>	1358.6	32.0	1253.0	29.6	105.6	2340

Өмнөговь аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2018 онд 32.0 мянга болж 2017 оныхоос 5.9 хувиар, 2016 оныхоос 13.0 хувиар, 2015 оныхоос 10.3 хувиар тус тус өссөн байна.


Өмнөговь аймагт нийт ажиллагчдын тоо 2018 онд 29.6 мянга болж, 2017 оныхоос 16.9 хувиар , 2016 оныхоос 21.8 хувиар , 2015 оныхоос 15.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2018 онд 105.6 мянга болж 2017 оныхоос 5.2 хувиар өсч, 2016 оныхоос 1.3 хувь буурч, 2015 оныхоос 9.5 хувиар өсчээ. 2018 онд нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 44.6 мянга буюу 42.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Өмнөговь аймгийн нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2018 онд 2340 болж 2017 оныхоос 52.9 хувиар, 2016 оныхоос 42.3 хувиар, 2015 оныхоос 31.8 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2018 онд 7.8 функт болж 2017 оныхоос 1.0 функт, 2016 оныхоос 2.2 функтээр, 2015 оныхоос 0.3 функтээр тус тус буурсан байна.


ЗУРАГ 2.1.АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН. 2013-2018 он



Өмнөговь аймагт ажилгүйдлийн түвшин 2018 онд 7.3 пункт болж 2017 оныхоос 9.1 пункт, 2016 оныхоос 7.0 пункт, 2015 оныхоос 4.5 пунктээр тус тус буурсан байна.

# НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД


## Бүлэг 3



### 3.1.БОЛОВСРОЛ. СОЁЛ. УРЛАГ


Улсын хэмжээнд 2018/2019 оны хичээлийн жилд цэцэрлэгт 261.4 мянган хүүхэд хамрагдсан нь 2017/2018 оны хичээлийн жилээс 1.7 хувиар, 2016/2017 оны хичээлийн жилээс 6.8 хувиар, 2015/2016 оны хичээлийн жилээс 13.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 3.1.1. ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО, СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, мянган хүүхэд, . 2000-2018 он




Улсын хэмжээнд 2018/2019 оны хичээлийн жилд цэцэрлэгийн тоо 1435 байгаа нь 2017/2018 оны хичээлийн жилээс 1.3 хувиар, 2016/2017 оны хичээлийн жилээс 5.6 хувиар, 2015/2016 оны хичээлийн жилээс 10.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

### ХҮСНЭГТ 3.1.1. Ерөнхий боловсролын сургууль




Улсын хэмжээнд 2018/2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 803 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 80 (10.0 %) нь бага сургууль, 115 (14.3 %) нь дунд сургууль, 563 (70.1 %) нь ахлах сургууль, 45 (5.6 %) нь цогцолбор сургууль байна.

### ХҮСНЭГТ 3.1.2 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

ХҮСНЭГТ 3.1.3. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, сургалтын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар. 2008-2018 ОН



2018/2019 оны хичээлийн жилд өдрөөр суралцагчдын 93.3 хувь нь төрийн өмчийн сургуульд, 6.7 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

ЗУРАГ 3.1.3. ТӨРИЙН ХЭВШЛИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО, ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭР



## ЗУРАГ 3.1.4. 2017-2018 оны хичээлийн жилийн боловсролын тайлан

## Ерөнхий боловсролын сургууль

№	Үзүүлэлт	Хичээлийн жилээр			2019/2018 %
		2016-2017	2017-2018	2018-2019	
1	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	21	21	22	105
	12 жилийн	12	12	13	108
	9 жилийн	9	9	9	100
	бага	0	0	0	
2	Нийт бүлгийн тоо	413	431	431	100
3	Өдрийн ангид суралцагчид	11392	11844	12109	102,2
	Бүгдээс дотуур байранд суудаг	1001	868	881	101,1
4	Анги дүүргэлт	27.6	27.4	28,0	102,1
5	Элсэлт				
	1-р ангид	1276	1439	1518	105,5
	10-р ангид	152	663	691	104,2
6	Төгсөлт				
	9-р анги	200	953	970	101,8
	12-р анги	630	957	983	102,7
7	Багш нарын тоо	605	624	634	101,6
	Үүнээс: бага ангийн багшийн тоо	197	212	219	103,3
	Дунд, ахлах ангийн багш	408	284	415	146,1
	АББ-ын багш	14	6	7	116,7
8	Боловсролоор: Магистр	54	54	53	98,1
	Бакалавр	461	484	493	101,9
	Дипломын дээд	82	73	66	90,4
	Бусад	8	29	22	75,9

## СОЁЛ. УРЛАГ

Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо 2018 онд 289.5 мянга болж, 2017 оныхоос 4.6 хувиар, 2016 оныхоос 2.9 хувиар, 2015 оныхоос 7.1 хувиар тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 3.1.4. СОЁЛ УРЛАГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД. 2014-2018 ОН

	Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо. мян. хүн			Музейн үзэгчдийн тоо. мян. хүн			Номын сангийн тоо		
	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг
<b>2014</b>	271.5	32.6	4.3	608.4	93.6	8.1	380	101	15
<b>2015</b>	268.9	32.9	4.4	583.4	80.2	14.9	370	101	15
<b>2016</b>	281.1	34.3	4.4	534.7	87.3	19.4	362	101	14
<b>2017</b>	276.1	34.8	4.3	577.4	103.2	19.3	362	101	14
<b>2018</b>	289.5	37.3	4.1	781.4	145.5	47.9	364	102	15

Өмнөговь аймагт мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо 2018 онд 4.1 мянга болж, 2017 оныхоос 4.6 хувь, 2016 оныхоос 2.2 хувь буурсан байна.

Музейн үзэгчдийн тоо улсын хэмжээнд 2018 онд 781.4 мянга болж, 2017 оныхоос 26.1 хувь, 2016 оныхоос 31.5 хувь, 2015 оныхоос 25.3 хувь өссөн байна.




Өмнөговь аймагт музейн үзэгчдийн тоо 2018 онд 47.9 мянга болж, 2017 оныхоос 2.48 дахин, 2016 оныхоос 2,46 дахин, 2015 оныхоос 3,21 дахин тус тус нэмэгдсэн байна.

Номын сангийн тоо улсын хэмжээнд 2018 онд 364 болж, өмнөх оныхоос 0.5 хувиар өссөн байна.

### 3.2 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага 2018 онд 861 ажиллаж байгаагаас 197 их эмч, 211 дунд мэргэжилтэн ажиллаж байна.


ХҮСНЭГТ 3.2.1. НЭГ ИХ ЭМЧИД НОГДОХ ХҮНИЙ ТОО, 2011-2018 ОН



Улсын хэмжээнд нэг их эмчид ногдох хүний тоо 283 болж 2017 оныхоос 10 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 256 болж 3 хүнээр буурсан байна.


Өмнөговь аймагт нэг их эмчид ногдох хүний тоо 2018 онд 345 болж 2017 оныхоос 0.8 хувь 2017 оныхоос 0,58 хувь өсчээ. Харин нэг сувилагчид ногдох хүний тоо 2018 онд 362 болж 2017 оныхоос 1,89 хувиар буурчээ. Харин 2016 оныхоос 4,9 хувь, 2015 оныхоос 23,5 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3.2.2. НЭГ СУВИЛАГЧИД НОГДОХ ХҮНИЙ ТОО, 2011-2018 ОН




Амаржсан эх улсын хэмжээнд 2018 онд 77.0 мянга болж, 2017 оныхоос 4.1 хувиар өсч, 2016 оныхоос 1.0 хувиар, 2015 оныхоос 25.3 хувь, 2015 оноос 4.2 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 3.2.3. АМАРЖСАН ЭХИЙН ТОО. МЯН.ХҮН, 2011-2018 ОН




Өмнөговь аймагт амаржсан эхийн тоо 2018 онд 1536 болж, 2017 оныхоос 15.5 хувиар, 2016 оныхоос 8.7 хувь, 2015 оныхоос 1.7 хувиар тус тус буурчээ.

ЗУРАГ 3.2.4. АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО. МЯН.ХҮН, 2011-2018 ОН



Өмнөговь аймагт амьд төрсөн хүүхдийн тоо 2018 онд 1552 болж, 2017 оныхоос 16.1 хувиар, 2016 оныхоос 9.2 хувиар, 2015 оныхоос 3.0 хувиар тус тус өсчээ.

ЗУРАГ 3.2.5.ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, 2011-2018 ОН



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо улсын хэмжээнд 2018 онд 42.0 мянга болж, 2017 оныхоос 5.1 хувь, 2016 оныхоос 39.6 хувиар, 2015 оныхоос 29.2 хувиар тус тус буурсан байна.

Өмнөговь аймагт халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2018 онд 632 болж, 2017 оныхоос 11.4 хувиар, 2016 оныхоос 24.1 хувиар, 2015 оныхоос 36.0 хувиар тус тус буурсан байна.

# ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

## Бүлэг 4





Урьдчилсан гүйцэтгэлээр 2018 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9 хувь, төвийн бүсийн 19.5 хувь болох 597.3 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8.8 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хотын дараа 5-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 287.9 тэрбумд хүрч Улаанбаатар, Орхон аймгийн дараа 5-т тус тус орж байна.

ХҮСНЭГТ 4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр\* 2012-2018 он

	2015					2016				
	Дүнд эзлэх хувь					Дүнд эзлэх хувь				
	ДНБ, сая төг	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		ДНБ, сая төг	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ	
<b>Дүн</b>	<b>23150385.6</b>	<b>13.3</b>	<b>33.7</b>	<b>53.1</b>		<b>23 942 866.4</b>	<b>11.5</b>	<b>36.6</b>	<b>51.8</b>	
<b>Төвийн бүс</b>	<b>2348241.3</b>	<b>35.1</b>	<b>29.4</b>	<b>35.5</b>		<b>2 439 043.8</b>	<b>29.7</b>	<b>35.2</b>	<b>35.2</b>	
Говьсүмбэр	83724.4	25.8	30.7	43.5		83 354.9	20.0	38.3	41.7	
Дорноговь	261319.1	36.0	8.0	56.0		272 288.4	25.6	18.1	56.4	
Дундговь	237565.8	60.1	11.9	28.0		226 072.5	55.1	14.1	30.7	
<b>Өмнөговь</b>	<b>281273.5</b>	<b>32.8</b>	<b>20.9</b>	<b>46.3</b>		<b>404 035.8</b>	<b>22.5</b>	<b>42.9</b>	<b>34.7</b>	
Сэлэнгэ	574519.5	25.0	47.7	27.2		555 423.0	23.9	48.1	28.0	
Төв	542576.3	54.0	24.4	21.6		510 608.8	49.4	27.6	23.0	
	2017					2018**				
	Дүнд эзлэх хувь					Дүнд эзлэх хувь				
	ДНБ, сая төг	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		ДНБ, сая төг	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ	
<b>Дүн</b>	<b>27 876 297.2</b>	<b>10.1</b>	<b>41.4</b>	<b>48.5</b>		<b>32 093 615.4</b>	<b>10.8</b>	<b>41.6</b>	<b>47.6</b>	
<b>Төвийн бүс</b>	<b>2 870 828.4</b>	<b>25.0</b>	<b>41.9</b>	<b>33.2</b>		<b>3 068 821.3</b>	<b>31.7</b>	<b>34.9</b>	<b>33.4</b>	
Говьсүмбэр	83 959.4	20.8	38.0	41.2		91 702.8	21.3	33.7	45.0	
Дорноговь	296 014.8	27.3	17.4	55.3		349 617.2	32.9	17.3	49.8	
Дундговь	258 177.0	56.7	14.7	28.6		319 543.6	61.0	15.0	24.0	
<b>Өмнөговь</b>	<b>714 470.2</b>	<b>14.7</b>	<b>57.5</b>	<b>27.8</b>		<b>597 384.9</b>	<b>21.7</b>	<b>40.7</b>	<b>37.6</b>	
Сэлэнгэ	598 216.1	20.9	51.2	27.9		680 615.3	27.0	47.1	25.9	
Төв	510 446.5	40.9	34.0	25.0		594 206.5	48.0	29.7	22.2	

\*\* Урьдчилсан гүйцэтгэл


Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2014-2015 онуудад нэлээд бууралттай байсан боловч 2016-2017 онуудад огцом өсөлттэй байгаа нь дараах графикаас тодорхой харагдаж байна. /ЗУРАГ 4.1/

**ЗУРАГ 4.1 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДНБ, ЭЗЛЭХ ХУВЬ**




Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл: Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 21.7 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар нь 40.7 хувь, Үйлчилгээний салбар 37.6 хувийг тус тус эзэлж байна. /Зураг 4.2/

**ЗУРАГ 4.2 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДНБ-НИЙ БҮТЭЦ**



Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2014 онд 5.6 сая, 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.4 сая, 2017 онд 11.0 сая, 2018 онд 8.8 сая төгрөгт хүрсэн байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2016 оноос 2.4 сая төгрөгөөр өсч, харин өнгөрсөн оноос 2.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна./Зураг 4.3/

**ЗУРАГ 4.3 НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН**



# ТӨСӨВ, САХҮҮ

## Бүлэг 5





Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтэд 192.5 тэрбум төгрөгийг төлөвлөж, 137.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 71.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. 2018 онд орон нутгийн төсвийн зарлага төлөвлөсөн хэмжээнээс 54.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдахад төсвийн байгууллагуудын урсгал зардал 95.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан хэдий ч төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 48.6 хувьтай байгаа нь нөлөөлсөн байна.

2018 онд орон нутгийн төсвийн байгууллагууд 338.4 сая төгрөгийн өртэй, 1950.7 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

#### 5.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, оны үнээр мян.төгрөг

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Нийт орлого	74 282 951.7	62 892 780.6	64 822 838.7	114 971 315.0	163 718 636.5
Урсгал орлого	74 220 898.9	62 741 398.7	64 764 383.7	114 877 713.6	163 552 269.3
Татварын орлого	51 375 363.9	59 986 805.4	61 241 020.8	86 936 565.3	91 602 703.7
орлогын албан татвар	23 198 785.3	24 880 004.7	24 717 799.9	35 414 264.3	42 027 907.5
-аж ахуй нэгжийн		932 140.5	803 600.7	1 891 818.8	3 374 877.1
-хүн амын	23 198 785.3	23 947 864.2	23 914 199.2	33 522 445.5	38 653 030.4
Өмчийн татвар	10 302 913.0	12 683 668.1	13 369 191.7	25 065 724.1	23 083 712.1
Бараа үйлчилгээний татвар	17 873 665.6	22 423 132.6	23 154 029.2	26 456 576.9	26 491 084.1
Автомашин татвар	1 899 313.1	1 727 722.6	2 684 543.3	2 818 687.5	3 472 937.9
Бусад татвар төлбөр хураамж	15 974 352.5	20 695 410.0	20 469 485.9	23 637 889.4	23 018 146.2
Татварын бус орлого	22 845 535.0	2 754 593.3	3 523 362.9	27 941 148.3	71 949 565.6
Хөрөнгийн орлого	62 052.8	151 381.9	58 455.0	93 601.4	166 367.2

#### 8.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр, оны үнээр мян.төгрөг

Эдийн засгийн үйл ажиллагаагаар	2014	2015	2016	2017	2018
<b>Нийт зардал</b>	<b>25 724.1</b>	<b>35 904.9</b>	<b>56 340.8</b>	<b>2 063 251.7</b>	<b>102 884 259.1</b>
Боловсрол үйл ажиллагаа	12 186.4	16 147.0	30 051.1	1 319 639.5	89 234 172.9
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	7 176.4	10 110.7	12 802.2	615 043.6	2 227 838.7
Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	6 159.5	8 965.7	12 000.7	0.0	133 541.0
Барилга, хот байгуулалт	0.0			24 959.4	6 386 850.4
Эдийн засгийн бусад	201.8	681.5	1 486.8	103 609.2	4 901 856.1



Аймаг дахь банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 276.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 20.2 тэрбум төгрөгөөр буюу 7.9 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 104.3 тэрбум төгрөгөөр буюу 60.5 хувиар тус тус өссөн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 4.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 0.3 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар буурчээ.

Өмнөговь аймгийн хэмжээнд ПОС, ПОБ терминал машин 1025 ширхэг, АТМ, БМОМашин 58 ширхэг, давхардсан дүнгээр мобайл банк хэрэглэгчдийн тоо 39190, интернэт банк хэрэглэгчдийн тоо 33261, картаар үйлчлэгч иргэн 913, байгууллага 93 байна.


Аймаг дахь банкуудын нэгжид нийт давхардсан тоогоор 141478 иргэн, хуулийн этгээдийн харилцах данс, 76378 иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн данс тус тус байршиж, нийт 29631 иргэн, хуулийн этгээд зээлийн үлдэгдэлтэй байна.

## 7.2 ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖ, аймаг, жилийн эцсийн байдлаар/ мян.төгрөг/

Банкууд	2014	2015	2016	2017	2018
<b>Бүгд</b>	<b>73 765 011.8</b>	<b>74 911 276.4</b>	<b>91 973 647.0</b>	<b>122 019 658.0</b>	<b>152 220 016.0</b>
ХААН	38 726 815.0	39 252 536.7	44403884.9	50 998 706.9	60 657 604.1
ХАС	5 142 873.1	4 996 043.0	9724920.6	13 904 149.6	19 643 458.9
Капитал	491 070.5	421 207.8	402659.5	432 051.1	820 535.2
ҮХО банк	106 821.5	100 631.9	506233.2	4 472 931.4	9 767 466.2
Төрийн банк	16 884 663.4	13 823 750.5	17330987.3	25 970 417.8	27 864 562.9
Голомт банк	7 737 550.4	9 784 704.2	14813865.9	17 780 022.2	23 422 828.9
ХХБанк	448 933.7	516 932.3	1017134.5	2 560 090.6	3 915 662.2
Капитрон банк Чингис хаан банк	930 554.5	2 770 085.9	3773961.1	5 901 288.4	6 127 897.6
Хас-Цогтцэций	3 295 729.7	3 245 384.1		...	
Хас-Цогтцэций	10885794.2	10503130.2		...	

ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

# Бүлэг 6



## 6.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Манай аймгийн нийт өрхийн 27.1 хувь буюу 5951 малчин өрх эзэлж байна. Мал аж ахуйн салбарт 9593 малчид ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2013 онд 285.7 мянган малчин байсан бол 2015 онд 297.8 мянга буюу 4.2 хувиар өссөн, 2018 оны жилийн эцсийн байдлаар 288.7 мянга болж 2015 оноос 3.1 хувиар буурсан байна.

### ХҮСНЭГТ 6.1.1. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛЧДЫН ТОО/2013-2018 он/

	2013	2014	2015	2016	2017	2018
Малчин өрхийн тоо	5173	5216	5417	5647	5819	5951
Малчдын тоо	9226	9449	9588	9846	9635	9593
Үүнээс: 16-34 насны	3534	3493	3473	3408	3084	3012
35-аас тэтгэвэрт гарах хүртэл	4706	4944	5135	5353	5079	5151
Тэтгэврийн насны	986	1012	980	1085	1431	1430


Мал тооллогын 2018 оны аймгийн дүнгээр нийт малчин өрх 77.3 хувь цахилгааны эх үүсвэртэй, 73.8 хувь нь телевизортой, 51.7 хувь нь автомашинтай 48.7 хувь мотоцикльтой байна. Улсын хэмжээнд малчин өрхийн тоо 2013 онд 145.3 мянга байсан бол 2018 оны байдлаар 169.7 мянга болж 24.4 мянган малчин өрхөөр өссөн байна.

### ХҮСНЭГТ 6.1.2. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛЧИН ӨРХИЙН ТОО /СУМДААР/

Сумын нэр	2014	2015	2016	2017	2018
Баяндалай	379	418	423	428	428
Баяновоо	298	307	322	328	331
Булган	331	359	370	352	370
Гурвантэс	539	546	592	615	637
Мандаловоо	301	298	304	317	339
Манлай	471	478	479	461	468
Номгон	483	508	522	554	545
Ноён	227	227	246	253	264
Сэврэй	340	351	347	348	362
Ханбогд	364	368	381	383	389
Ханхонгор	433	437	469	501	518
Хүрмэн	350	358	368	375	382
Цогтовоо	245	273	303	320	314
Цогтэций	229	264	267	289	312
Даланзадгад	226	225	254	295	292
ДҮН	5216	5417	5647	5819	5951

Өмнөговь аймаг 1971 онд 6 мянган малчинтай байсан бол 2000 онд 15 мянга болж 2.5 дахин өсч байсан бол харин 2018 оны эцэст 9.6 мянга болж 2000 онтой харьцуулахад буюу сүүлийн 10 гаруй жилд 36.0 хувиар буурсан байна.

## МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮТЭЦ




Манай улсын малын тоо 2018 оны эцэст 66.5 сая толгойд хүрч, 2010 оныхоос 2 дахин өслөө. Үүний дотор адуу 3940.1 мянга, тэмээ 459.7 мянга, үхэр 4380.9 мянга, хонь 30554.8 мянга, ямаа 27124.7 мянга болж таван төрөл дээрээ өссөн байна.

## ХҮСНЭГТ 6.1.3 МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, МЯН.ТОЛ /улсын дүнгээр/

	1918*	1940	1960	1980	1990	2000	2010	2018
Бүгд	9 645.6	26 204.8	23 000.5	23 771.4	25 856.9	30 227.5	32 729.5	66 460.2
Адуу	1 150.5	2 358.1	2 502.7	1 985.4	2 262.0	2 660.7	1 920.3	3 940.1
Тэмээ	228.7	643.4	859.1	591.5	537.5	322.9	269.6	459.7
Үхэр	1 078.4	2 722.8	1 905.5	2 397.1	2 848.7	3 097.6	2 176.0	4 380.9
Хонь	7 188.0	15 384.2	12 101.9	14 230.7	15 083.0	13 876.5	14 480.4	30 554.8
Ямаа		5 096.3	5 631.3	4 566.7	5 125.7	10 269.8	13 883.2	27 124.7


1940 онд нийт сүргийн 19.4 хувийг ямаа, 58.7 хувийг хонь, 10.4 хувийг үхэр, 9.0 хувийг адуу, 2.5 хувийг тэмээ эзэлж байсан бол 2018 онд 40.8 хувийг ямаа, 46.0 хувийг хонь, 6.6 хувийг үхэр, 5.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

ЗУРАГ 6.1.2 МАЛЫН ТОО, МЯН.ТОЛ /улсын дүнгээр/




Өмнөговь аймаг нь тэмээний тоо толгойгоороо улс, бүсдээ ихээхэн хувийг эзэлдэг бөгөөд 1980 оноос хойш бүсдээ тогтмол 50-иас дээш хувь, улсадаа 2010 оноос 30-иас дээш хувийг эзэлж байна.

ЗУРАГ 6.1.3. ТЭМЭЭНИЙ ТОО ТОЛГОЙН УЛС, БҮСИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Ямааны тоо толгой бүсэд эзлэх хувь нь 2018 онд 25.3 хувьд хүрч 2013 оноос 1.1 функтээр, улсын хэмжээнд эзлэх хувь 6.2 болж 2013 оноос 0.3 функтээр өссөн байна.

#### ЗУРАГ 6.1.4. ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН УЛС, БҮСИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Аймгийн хэмжээнд 2018 оны мал тооллогоор 2598440 толгой мал тоолуулсан байна. Мөн 476 мянгат малчинтай болсон.

#### ХҮСНЭГТ 6.1.4. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛЫН ТОО, СУМДААР

Сум/дүүрэг	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
	2 598 440	152 281	96 544	26 864	631 412	1 691 339
Даланзадгад	108 886	2 737	3 260	1 826	28 527	72 536
Баяндалай	175 787	4 579	6 799	2 373	34 073	127 963
Баян-Овоо	142 224	7 334	6 624	1 368	38 092	88 806
Булган	205 265	6 702	7 426	2 954	68 174	120 009
Гурвантэс	187 458	8 055	3 554	445	9 997	165 407
Мандал-Овоо	209 916	23 856	7 232	1 223	64 599	113 006
Манлай	205 418	14 200	12 519	1 947	70 684	106 068
Ноён	108 306	6 345	2 143	223	10 615	88 980
Номгон	262 292	8 764	6 558	2 059	41 985	202 926
Сэврэй	172 662	6 408	5 940	1 528	25 464	133 322
Ханбогд	165 527	30 431	7 979	5 022	45 468	76 627
Ханхонгор	236 686	7 736	8 520	2 012	69 988	148 430
Хүрмэн	142 790	10 013	5 763	1 087	31 160	94 767
Цогт-Овоо	140 197	11 994	3 956	941	46 012	77 294
Цогтцэций	135 026	3 127	8 271	1 856	46 574	75 198

## ГАЗАР ТАРИАЛАН



Улсын хэмжээгээр 2018 оны байдлаар нийт 777.2 мян.га талбайд тариалалт хийснээс 366.8 мян.га-д үр тариа, 12.9 мян.га-д төмс, 8.9 мян.га-д хүнсний ногоо, 46.3 мян.га-д тэжээлийн ургамал, 342.3 мян.га-д техникийн ургамал, жимс, жимсгэнэ тариалсан нь 2013 оныхоос нийт тариалсан талбай 361.7 мян.га-гаар буюу 87.1 хувь өссөн байна.

### ХҮСНЭГТ 6.1.5 ТАРИАЛСАН ТАЛБАЙ/мян.га/

	1960	1970	1980	1990	2000	2010	2012	2013	2018
Үр тариа	246.7	419.6	557.5	654.1	194.7	259.2	306.2	293.3	366.8
Төмс	2.2	2.9	7.5	12.2	7.9	13.8	16.8	15.5	12.9
Хүнсний ногоо	0.8	1.4	2.4	3.6	5.4	7	7.9	8.3	8.9
Тэжээлийн ургамал	15.7	30.8	136.7	117.8	0.8	11.1	13.8	14.4	46.3

Өмнөговь аймагт 1980 онд 391.1 га талбайд тариалан эрхэлж байсан бол 2018 онд 253.1 га талбай болж буурсан байна. Нийт талбайн 28.1 хувь буюу 71.1 га талбайд төмс, 57.6 хувь буюу 145.9 га талбайд хүнсний ногоо, 14.3 хувь буюу 36.1 га талбайд тэжээлийн ургамал тариалжээ.

### ХҮСНЭГТ 6.1.6. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТАРИАЛСАН ТАЛБАЙ га

	1980	1990	2000	2010	2012	2013	2018
Нийт тариалсан талбай	391.1	143.9	170	155.6	177.1	144.7	253.1
Төмс	32.9	78.9	87.7	83.2	65.8	64.5	71.1
Хүнсний ногоо	18.2	55.5	82.3	44.9	48.2	45.5	145.9
Тэжээлийн ургамал	340	9.5	0	27.5	63.1	34.7	36.1

Улсын хэмжээнд 2018 онд 453.8 мян.т үр тариа, 168.9 мян.т төмс, 100.7 мян.т хүнсний ногоо, 123.8 мян.т тэжээлийн ургамал хураасан нь 2013 оныхоос үр тариа 17.2 хувиар, тэжээлийн ургамал 2.9 дахин өссөн бол, хүнсний ногоо 11.8 хувиар, хүнсний ногоо 1.1 хувиар тус тус буурсан байна.

#### ХҮСНЭГТ 6.1.7. ХУРААСАН УРГАЦ мян.тонн

	1960	1970	1980	1990	2000	2010	2012	2013	2018
Үр тариа	259.5	326.5	286.8	718.3	142.1	355.1	479.3	387.0	453.8
Төмс	18.5	22	39.3	131.1	58.9	168	245.9	191.6	168.9
Хүнсний ногоо	6.9	12.6	26	41.7	44	82.3	98.9	101.8	100.7
Тэжээлийн ургамал	34.4	47.5	102.8	527.1	4.1	34.8	46.2	42.6	123.8

Өмнөговь аймаг 1980 онд 827.6 тонн тэжээлийн ургамал, 297.1 тонн төмс, 203.3 тонн хүнсний ногоо хурааж байсан бол 2018 онд 571.6 тонн төмс, 1050.2 тонн хүнсний ногоо, 229.7 тонн тэжээлийн ургамал хурааж, бэлтгэн авчээ.

#### ХҮСНЭГТ 6.1.8. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХУРААСАН УРГАЦ тонн

	1980	1990	2000	2010	2012	2013	2018
Төмс	297.1	519.3	624.5	621.1	636.8	552.1	571.6
Хүнсний ногоо	203.3	573.5	650	408.5	474.4	499.7	1050.2
Тэжээлийн ургамал	827.6	74.8	0	266.6	281	191.8	229.7

## 6.2. АЖ ҮЙЛДВЭР


2018 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2361.1 тэрбум төгрөг болж 2014 оноос 5.4 дахин буюу 1924.5 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 86.1 хувиар буюу 1092.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. /Хүснэгт-6.1/ /ЗУРАГ 6.1/

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувиар нь авч үзвэл: уул, уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт 99.9 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 6.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, үнийн дүнгээр

Бүтээгдэхүүний нэрс	Үнийн дүнгээр (мян.төг)					2018 2017
	2014	2015	2016	2017	2018	
Чулуун нүүрс	431184237.2	361337455.1	705142136.1	1264798536	2356963660	186.4
Алт	93252.5	0	253346.5	0	0	
Дулааны эрчим хүч	2183701.9	2463245.9	2470555	2524017.5	2764798.5	109.5
Хиамны зүйл	338027.7	183019	70863.8	0	0	
Боловсруулсан шингэн сүү	180689.2	119677.8	72313.7	96220.1	120155	124.9
Нарийн боов	20502.2	116828.2	235139.5	13339.5	5292.3	39.7
Архи	370323.5	324750.8	299512.7	227176.3	336477.3	148.1
Түгээсэн цэвэр ус	502216.9	548483.2	613450.1	624383.5	569209.1	91.2
Сувагжуулалт	270698	318673	373435.6	400116.2	376563.4	94.1
<b>Бүгд</b>	<b>436555542.5</b>	<b>366761382.6</b>	<b>709530753</b>	<b>1268683789</b>	<b>2361136156</b>	


ЗУРАГ 6.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, 2014-2018 оноор, оны үнээр, тэрбум.төг



ХҮСНЭГТ 6.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 оноор

Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Биет хэмжээ					2018
		2014	2015	2016	2017	2018	2017
Чулуун нүүрс	мян.тн	7880.3	9771.2	17691.2	22884.8	20844.3	91.1
Алт	кг	1.4		3.1			
Дулааны эрчим хүч	мян.Гкал	40.1	43.5	50.1	50.6	59.0	116.6
Хиамны зүйл	тн	67.6	34.7	14.6			
Боловсруулсан шингэн сүү	мян.л	63.8	47.3	28.8	43.8	48.00	109.6
Нарийн боов	тн	8.5	47.9	118.6	7.5	2.85	38.0
Архи	мян.л	18.7	12.9	12	9.6	12.5	130.2
Түгээсэн цэвэр ус	мян.м3	221.4	228.1	253.1	272.6	245.4	90.0
Сувагжуулалт	мян.м3	155.1	169.3	195.6	213.9	203.9	95.3

ЗУРАГ 6.2 ЧУЛУУН НҮҮРС ОЛБОРЛОЛТ, 2014-2018 он, мян.тн



#### 4.БАРИЛГА




Барилга угсралт их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно.

#### ХҮСНЭГТ 7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг

	2015	2016	2017	2018
Улсын дүн	2946448.8	2928735.2	2926822.1	4009817.5
Төвийн бүс	419994.6	443219.8	821381.4	1417255.0
Говьсүмбэр	17572.4	10689.8	3802.1	3423.1
Дархан-уул	57374.9	79659.2	38812.8	91114.5
Дорноговь	28878.8	17046.2	95213	423281.8
Дундговь	21406.3	11230.2	8003.1	9515.0
Өмнөговь	226438.2	295485.2	562661.7	732711.8
Сэлэнгэ	35177.7	9146.0	83716.1	13216.6
Төв	33146.2	19963.1	29172.6	143992.2

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2018 онд 732.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2017 оноос 1.3 дахин өсч бүсийн дүнд 51.7 хувь, улсын дүнд 18.3 хувийг эзэлж байна.

#### ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг



## 8.ТЭЭВЭР, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ



Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүдэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км, ажиллагсдын тоо орлого зэрэг орно.

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Улсын

бүртгэл статистикийн ерөнхий газарт дамжуулдаг.

*Тээсэн ачаа эргэлт:* Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

*Зорчигч тээвэр эргэлт:* Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ

2018 онд 14.5 мян.тн ачаа тээвэрлэж, 4355.3 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 423 мян.тн-оор буурч, ачаа эргэлт 15 дахин буурсан гүйцэтгэлтэй байна. Тээвэр бүхий байгууллагууд 2859.7 мян.хүн тээвэрлэж, 90036.4 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 117.5 хувиар буюу 1544.9 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 47.7 хувиар буюу 82225.2 мян.хүн.км-ээр буурсан гүйцэтгэлтэй байна. Тээврийн орлого 8595.1 сая төгрөг болж өнгөрсөн оноос 32.5 хувиар буюу 4130.7 сая төгрөгөөр буурсан байна.

### ХҮСНЭГТ 8. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2018/2017
Ачаа эргэлт	мян.тн.км	28307.3	65206.6	4355.3	-
Тээсэн ачаа	мян.тн	425.25	437.5	14.5	-
Зорчигч эргэлт	мян.хүн.км	117886.4	172261.6	90036.4	52.3
Үүнээс: дотоодод	мян.хүн.км	117886.4	172261.6	90036.4	52.3
Тээсэн зорчигч	мян.хүн	973.3	1314.8	2859.7	217.5
Үүнээс: дотоодод	мян.хүн	973.3	1314.8	2859.7	217.5
Тээврийн орлого	сая.төг	13058.5	12725.8	8595.1	67.5
Тээврийн ажиллагсад	хүн	276	466	386	82.8


## ХҮСНЭГТ 9. АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ

Аймаг нийслэл	Үүнээс:									
	2016	2017	2018	Төрлөөр				Ашигласан хугацаагаар		
				суудлын	ачааны	автобус	тусгай зориулалтын	3 жил хүртэл	4-9 жил	10-аас дээш
Бүгд	499 152	536 399	585363	426065	131573	18570	9155	11666	120512	453185
Төвийн бүс	54206	60 425	67905	41164	22902	2361	1478	613	12937	54355
Говьсүмбэр	2 269	2 333	2311	1686	499	67	53	12	305	1 994
Дархан-Үул	9 725	9 152	8941	5970	2500	341	130	40	989	7912
Дорноговь	9 268	11 155	11909	8185	2972	414	338	111	1 393	10405
Дундговь	2 961	2 954	2818	1677	872	216	53	26	224	2568
Өмнөговь	13441	16 487	22700	12625	8584	765	726	339	7961	14400
Сэлэнгэ	8 404	10 403	11219	6767	4037	291	124	69	1320	9830
Тов	8 138	7 941	8007	4254	3438	267	48	16	745	7246

Эх үүсвэр: Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын мэдээлэл


